

15

ОЙРЫН ЖИЛҮҮДИЙН ХУВЬЧЛАЛ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Н.Ганбямба

Монгол улс дахь өмч хувьчлал арав гаруй ажил үргэлжилж байна. Өмч хувьчлалын үйл явцыг макро түвшинд судлаж дараах дүгнэлт хийж байна.

1. Төрийн өмчинд байгаа бодит баялагийг эдийн засгийн илүү үр ашигтай ашиглах, эдийн засгийн үр ашгаар дамжин гардаг бусад зерэг үр дагаварыг нэмэгдүүлэх зорилгоор хувийн өмчинд шилжүүлэх төрийн бодлогоор хэрэгждэг зохион байгуулалттай арга хэмжээг өмч хувьчлал гэнэ.

2. Өөрийн орны хувьчлалыг шилжилтийн эдийн засагтай орнуудын хувьчлалтай харьцуулахад тэдгээр орнуудын болон манай улсын хувьчлал нь өмч хувьчлалын түүхэнд тодорхой хугацааг хамарсан, нийгэм, эдийн засаг, улс төрийн цогцолбор зорилтыг дэвшиүүлсэн, тухайн орны онцлогийг тусгасан өргөн хувьчлал болж байна. Өргөн хувьчлал нь зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн нэг гол хэрэгсэл бөгөөд Монгол улс дахь өмч хувьчлал нь шилжилтийн орны өргөн хувьчлалын шинж чанарыг бүрэн агуулсан уул хувьчлалын бүрэлдэхүүн хэсэг мөн. Манай улсын эдийн засаг, нийгмийн байдлын ялгаанаас болж хувьчлалын онцлог олон хэлбэрээр илэрч байна.

3. Монгол улс дахь хувьчлал цаашид үргэлжилэх болно.

Ойрын жилүүдийн хувьчлалд хамрагдах гол объектууд нь газар, үнэ цэнэтэй аж ахуйн нэгжүүд, нийгмийн салбар, бусад объект, эд хөрөнгө байна.

Хувьчлалын онцлог

Нэг. Ойрын жилүүдэд газар, үнэ цэнэтэй аж ахуйн нэгжүүд, нийгмийн салбарыг хувьчлах өргөн ба ердийн хувьчлал хослон явагдана. Үүнээс үндэслэн дараах байдал илэрч байна.

Нэгдүгээрт. Монгол улсад шилжилтийн үеийн өргөн хувьчлал ба ердийн хувьчлал хослон ойрын жилүүдэд хийгдэнэ.

Хоёрдугаарт. Энэ үеийн хувьчлалыг шилжилтийн өргөн хувьчлалын туравдахь шат буюу төгсгөлийн шат гэж үзэж болохоор байна.

Хоёр. Монгол улсад ойрын жилүүдэд хийх хувьчлал нь урьдынхаас илүүтэй үүрэг хариуцлагатай, тухайн салбарын төдийгүй, нийт эдийн засгийн ёсөлт, үр ашигт шууд хүчтэй нөлөөлөх хувьчлал байх болно.

Хувьчлах гол зорилго

Газар хувьчлалын эхний шатыг холбогдох хууль тогтоомжийн дагуу ойрын хугацаанд эрчимтэй хэрэгжүүлэх замаар иргэдийг газартай болгож, түүнийг эдийн засгийн идэвхтэй эргэлтэнд оруулах боломжийг хангах,

Үнэ цэнэтэй аж ахуйг хувьчлахад ашигт ажиллагааны өндөр тувшинд ажиллуулах, улсын төсөвт өмнөх үеэс илүү орлого оруулах, их хэмжээний хөрөнгө оруулалт хийх, дэвшилт технологи нэвтрүүлэх, орчин үеийн менежмент хэрэглэхэд илүүтэй анхаарах,

Нийгмийн салбарыг хувьчлахад уул салбарыг үр ашигтай ажиллуулах, арга ажиллагааг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэх, орчин үеийн менежмент хэрэглэх, иргэдийг найдвартай, чанартай үйлчилж, үйлчилгээг өргөтгөх зэрэгт анхаарах нь хувьчлалын зерэг үр дагаварт мэдэгдэхүйц сайн нөлөө үзүүлэх явдал гэж үзэж байна.

Ойрын жилүүдийн хувьчлалд анхаарах асуудал

Өмнөх хувьчлалын үйл явцад олсон амжилтыг бэхжүүлэх, дутагдал гажуудлыг гаргахгүй байх нь хамгийн түрүү анхаарах асуудал байна. Үүнтэй холбогдуулан дараах асуудлыг тоочиж байна.

Монгол улс дахь өмч хувьчлалын явцад зерэг ба сөрөг үр дагавар их хэмжээгээр гарлаа. Сөрөг үр дагавар гараад олон хүчин зүйл нөлөөлсөн боловч өргөн хувьчлал хийх нөхцөл бололцоо бүрэн бурдээгүй байсан нь илүүтэй нөлөөлсөн байна. Өөреөр хэлбэл, монголд өргөн хувьчлал хийхэд шаардлагын талаас илүүтэй анхаарч хувьчлалыг хэрэгжүүлж үр дүнд хүргэх нөхцөл бололцоо буюу орчинг бага анхаарсан байна. Иймд хувьчлах асуудалд шаардлага ба нөхцөл бололцоог нарийн тооцож хувьчлах шаардлагатай бөгөөд нөхцөл бололцоо хангасан объектуудыг хувьчлах зарчим цаашид баримтлах хэрэгтэй байна. Хувьчлалын үр дагаврыг хувьчилсан аж ахуйн нэгжийн тоо, тухайн салбарын хувьчлалд хамрагдсан хувь хэмжээгээр тооцох нь хувьчлалын үндсэн зорилгыг тэр бүр хэрэгжүүлж чадахгүй байгааг судалгаа олон талаас харуулав.

Хувьчлалын шууд нөлөөн дор буюу голлох нөлөөгөөр макро түвшинд шийдэгдэх эдийн засаг, нийгэм, улс төрийн зангилаа асуудлууд нь хувьчлах шаардлага болох бөгөөд үүнийг үндэслэн хувьчлалын зорилго, чиглэл, үр дагаварыг үнэлэх хэмжүүрийг хэрэглэх нь зөв хувьчлах арга зүйн чухал үндэслэл болно.

Хувьчлах бэлтгэл болон хувьчилсан аж ахуйн нэгжүүд хэвийн ажиллах орчинг хувьчлах нөхцөл бололцоо гэж үзэж байна. Хувьчлах нөхцөл бололцоо нь хувьчлалыг ямар арга замаар хэрхэн хийх, ямар арга хэрэглэх, ямар хугацаанд хувьчлах зэргийг шийдэх үндэслэл болохын дээр хувьчлалын үйл явц, үр дагаварыг үнэлэх, шалтгааныг тодорхойлох хэмжүүр болно.

Ийм учраас ойрын жилүүдийн хувьчлалд шаардлага ба нөхцөл бололцоог онцгой анхаарах хэрэгцээ бий.

Ойрын жилүүдэд хийгдэх хувьчлалын онцлог, ач холбогдолыг харгалзан үзэж түүнийг хэрэгжүүлэх чиглэл, үзэл баримтлал, арга замыг тусгайлан авч үзэх хэрэгтэй юм.

Үнэ цэнэтэй аж ахуйн нэгжүүдийг тендерт шалгаруулахад нэрлэсэн доод үнээс илүү гарсан санхүүгийн санал, өрсөлдөгчөөс давсан үнэ, хувьчилсны дараах ойрын хугацаанд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээнээс гадна хувьчилсан аж ахуйн нэгжийн хэтийн үйл ажиллагааны үр дүнг тун нарийн тооцох шаардлага байна. Тухайлбал тендерт ялагчийн санал болгож буй хэтийн бизнес төлөвлөгөөг тун сайн судлах нь чухал юм.

Хувьчлалын гол үр дүнгийн нэг бол өмчлөлийн харилцааг үндсээр нь өөрчилж зах зээлийн нөхцөлд нийцсэн өмчлөлийн шинэ харилцаа бүрэлдэн тогтох байгаа явдал бөгөөд үүнтэй уялдан уялдуулан хувьчлалтай холбон дараах асуудлуудыг шийдэх хэрэгцээ гарч байна.

- Өмчлөлийн харилцааг өргөн хүрээнд судлах,
- Өмчлөлийн харилцааны хүрээнд үүсч байгаа ба үүсч болзошагүй зөрчлийг хэрхэн шийдэх асуудал боловсруулах
- Өмчлөлийн шинээр бүрэлдэн буй харилцааг бэхжүүлэх арга хэмжээ авах
- Өмчлөлийн харилцааг зохицуулах төрийн бодлого боловсруулах

Хувьчлалын хууль эрх зүйн орчин харьцангуй сайн байгаа боловч хувьчлалын үйл явцад шинэ шинэ зүйл байнга гарч эрх зүйн баталгаа шаардсаар байна. Үүний зэрэгцээ өмнөх хууль тогтоомжийг өөрчлөх, шинэчлэх хэрэгцээ ч тасралтгүй гарч байна.

- Өмчлөлийн харилцааны хуультай болох
- Өргөн хувьчлал явуулах ба салбарын хувьчлалын тухай хууль гаргах
- Өмч хувьчлалтай холбогдон гарсан хууль тогтоомжид өөрчлөлт, шинэчлэлт хийх,
- Олон хэлбэрийн өмчүүд болон төрийн ба орон нутгийн өмчийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулах,
- Зарим хуулийн хэрэгжилттэй, тухайлбал “Дангаар ноёрхолын эсрэг тэмцэх тухай хууль”-н хэрэгжилттэй холбогдсон арга хэмжээ авах,
- Хувьчлагдсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлэх эрх зүйн арга хэмжээ авах

Хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдийг дэмжих эдийн засгийн макро түвшиний арга хэмжээ ойрын жилүүдэд зайлшгүй чухал хэвээр байна.

Үүний тулд:

- Хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн гадаад орчинг сайжруулах
- Хувьчлагдсан аж ахуйн нэгжид технологийн дэвшил хийхэд нь засгийн газар дэмжлэг, туслалцаа үзүүлэх,

Хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх бие даасан бодлого хэрэгжүүлэх, зохицуулалтыг сайжруулах явдал чухал. Үүнтэй холбогдон эдийн засгийн үр ашгийн багц үзүүлэлтийг тулгуур шалгуур болгох хэрэгцээ хэвээр байна. Манай өнөөгийн нөхцөлд эдийн засгийн үр ашгийн дараахд багц үзүүлэлтийг санал болгож байна.

- Татвар ба төсөвт төлөх хураамжийг хувьчлахаас өмнөх хэмжээнээс бууруулахгүй байх,
- Ашигтай ажиллах үйл ажиллагааг өргөтгөх,
- Ногдол ашгийг тогтмол хуваарилах,
- Үндсэн үйл ажиллагааны хүрсэн хэмжээ, түвшинг бууруулахгүй байх,
- Хувьчилсан бодит баялагийг аривжуулах,
- Нийгмийн үр ашгийн бусад үзүүлэлт

Үүний зэрэгцээ салбар, объектын онцлогтой холбогдуулан эдийн засаг, нийгмийн зэрэг үр дагаварын багц үзүүлэлтүүдийг өмч хувьчлах хетөлбөрт тусгайлан зааж, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх хэрэгтэй юм.

Төрд одоогоор байгаа өмчийн тухайд ч онцлог анхаал тавих ёстой. Төр одоо байгаа өмчийг шаардлагатай багц үзүүлэлтээр тооцоо тооллого хийж, хувьчлал болон бусад чиглэлээр ашиглах өргөн хүрээтэй судалгаа шинжилгээ хийх, төрийн мэдэлд үлдэх аж ахуйн нэгж бүр дээр эдийн засаг, нийгэм, аюулгүй байдал, олон улсын эдийн засгийн харилцаа, иргэдийн ахуй амьдрал, төрийн засаглалын үйл ажиллагааг гүйцэтгэхэд болон хэний өмч байвал илүү үр өгөөжтэй байх талаар үнэлэлт дүгнэлт хийвэл зохино. Цаашдын хувьчлалд шинжлэх ухааны бүрэн үндэслэлтэй хандах нь хувьчлалыг төгөлдөржүүлэх цогцолбор арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үүнтэй холбогдуулан төрийн өмчийг дараахи чиглэлээр хуваарилах санал дэвшүүлж байна.

Үүнд:

1. Төрд одоо байгаа өмчийг тоолж, судалгаа хийж, зориулалтын дагуу хуваарилах,

Үүнд:

- Төрд зайлшгүй үлдэх өмчийг тогтоох
 - Нөхцөл бололцоо бүрдсэн аж ахуйн нэгжүүд, үл хөдлөх хөрөнгийг хувьчлах
2. Үр ашгийн цогцолбор үзүүлэлтийг хувьчлах тулгуур шалгуур болгох
 3. Тухайн салбар, тухайн объектын онцлогт тохирсон хувьчлалын баталгаат зэрэг үр дагавар гарах арга хэрэглэх

4. Хувьчлах бэлтгэл хангах ба хувьчилсны дараах тааламжтай нөхцөл бололцоо бүрдүүлэх

Манай улс өмчийн олон хэлбэр бүхий эдийн засагтай болж байгаатай холбогдуулан төрийн ба орон нутгийн өмчлөлийн удирдлагыг төлөвшүүлэх ч хэрэгцээ гарч байгааг өмч хувьчлалтай холбон авч үзэх асуудлын нэг гэж үзэж байна.

Бидний судалгаанд гарсан хүндрэлийн нэг бол төрийн өмч хувьчлалтай холбогдсон статистик мэдээ материал үнэхээр хомс, зарим салбар, удирдлагын тодорхой түвшинд ч төрийн өмч хувьчлалын статистик мэдээлэлгүй, байгаа мэдээ материал нь олон газар тарамдсан, динамик бүртгэл үгүй, мэдээллийн анхан шатны боловсруулалт хийдэггүйгээс гадна тэдгээрийг хариуцан зохион байгуулах удирдлага дутагдаж байгаа нь харагдае. Олон жилээр үйл ажиллагаа явуулж байгаа эдийн засаг, нийгэм, улс төрийн зангилаа бөгөөд Монгол улсын үнэт баялагтай шууд холбоотой ийм асуудал нэгдсэн бүртгэл тооцоо муутай байгаа нь олон талын сөрөг нөлөөтэй байна. Үүнийг үндэслэн дараахи зөвлөмж гаргав.

Үүнд:

- Хувьчлагдсан аж ахуйн нэгж, үл хөдлөх хөрөнгийн анхан шатны бүртгэл бий болгох,
- Хувьчлагдсан аж ахуйн хөдөлгөөн, өөрчлөлтийн статистик динамиктэй болох
- Хувьчлагдсан аж ахуйн нэгжийн эдийн засгийн ба нийгмийн үр дагаварын статистик үзүүлэлт гаргах, тооцох,
- Өмч хувьчлалын статистик бий болгох нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ авах

Ойрын жилүүдийн хувьчлалын явцад давтагдан гарсаар байгаа дутагдал гажуудлыг цаашид гаргахгүй байх арга хэмжээг хувьчлалын хөтөлбөр, хувьчлалыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусган ажиллах нь ойрын жилүүдийн хувьчлалыг амжилттай болгох нэг нөхцөл юм.